

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дугаар сарын 29-ны өдөр 16:00 цагаас 17:35 цагийн хооронд Шангри -Ла зочид буудлын 1-р давхрын Боллруүм 2 хурлын танхимд хуралдаж, хурлын ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хураав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: Г.Баасанбат /Комиссын дарга/

Гишүүд: О.Золбоо

О.Хулан

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 112

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 537,718,474 ширхэг

Хурлын ирц: 86,13 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2023 оны 03 сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2023 оны 03 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр 2023 оны 03 сарын 20-ны өдөр, 2022 оны 04 сарын 05-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2023 оны 03 сарын 24-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, мөн www.investmentexpo.mn сайтад бүртгүүлсэн цахим хаяг руу цахим хэлбэрээр хурлын материалыг илгээж хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 06-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Г.Баасанбат: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 1 дүгээр асуудал: Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 2 дугаар асуудал: Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 3 дугаар асуудал: Компанийн 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- 4 дүгээр асуудал: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 5 дугаар асуудал: ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2022 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2022 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлогыг 69.7 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын орлого 4.9 тэрбум төгрөг, Нөхөн төлбөрийн зардал 11.1 тэрбум төгрөг, Үйл ажиллагааны зардал 9.7 тэрбум төгрөг, Цэвэр ашгийг 4.1 тэрбум төгрөгт хүрсэн.

2022 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө 39.9 тэрбум төгрөг, Эздийн өмч 29.1 тэрбум төгрөг, Нийт хөрөнгө 73.6 тэрбум төгрөгт хүрсэн.

2022 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 6,1% Эздийн өмчийн өгөөж (ROE) 14,4% байсан.

Мандал Даатгал ХК нь 2023 онд Нийт хөрөнгийн хэмжээгээр салбартаа 1-р байр, Мөнгөн хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ салбартаа 1-р байр, Нийт хураамжийн орлогоороо салбартаа 1-р байр, Хөрөнгө оруулалтын орлогоороо салбартаа 1-р байр, Цэвэр ашгаараа салбартаа 1-р байранд байгааг танилцуулав.

Нийт нөхөн төлбөрийн 20,196 тохиолдол гарсан нь өмнөх оноос 48% өссөн, нийт 11,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлсөн нь өмнөх оноос 36% өссөн, Эрүүл мэндийн даатгалын хувьд нөхөн төлбөрийн 13,049 тохиолдолд 3,2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр 2022 онд өгснийг танилцуулав.

Мандал Даатгал ХК-ны хувьд 2022 онд Нийгмийн хариуцлагын хүрээнд дараах онцлох үйл явдлууд болсныг танилцуулав. Үүнд:

1. Mandal Risk School хүүхдэд эрсдэлийн боловсрол олгох контент болон сургалтыг нэвтрүүлж 25,000 хүүхэд хамрагдсан.
2. Asuuna вэбсайтаар дамжуулан өсвөр насны 10,000 хүүхдэд бэлгийн боловсрол болон бусад тулгамдсан асуултад хариулж мэдээлэл өгсөн.
3. EDOCTOR эрүүл мэндийн вэбсайтын хандалт 565 мянгад хүрсэн.

4. ТУЗ-ийн даргын санаачилгаар 50 хүний амь нас аврах төслийн хүрээнд Улсын 3-р Төв Эмнэлэгтэй хамтран **Алтеплазаг** эмийг авч өгсөнөөр, зүрхний хурц шигдээс, тархины харвалт өгсөн 18 хүний амь насыг аварсан.
5. ОБЕГ-тай хамтран үеэр усны ослог бууруулах зорилгоор Туул голын эрэг дагуу хамгийн их хүн цуглардаг 2 байршилд аюулыг мэдээлэх 2 цамхгийг байгуулснаар тус байршилд 2022 онд үеэр усны ослоос үүдэлтэй эндэгдэл осол гараагүй байна.
6. Next Leaders 2022, Management Forum 2022, Mandal Risk forum 13дах жилдээ амжилттай зохион байгуулсан.

“Мандал Даатгал” ХК-ны хувьцааны үзүүлэлтийг танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ны нийт гаргасан хувьцааны тоо 624,301,600 ширхэг, 2022 оны 12 сарын 31-ны өдрийн хаалтын ханш 84.17 төгрөг, Зах зээлийн үнэлгээ 52.5 тэрбум төгрөг, 2022 онд нийт 2.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, 2022 оны өдрийн дундаж арилжаа 10.1 сая төгрөг байсныг танилцуулав.

Хувьцааны харьцаанууд: Р/Е харьцаа 12.9, Р/В харьцаа 1.8,

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ны ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдэлийн хороо аудитын байгууллагад сонгон шалгаруулалт явуулахдаа заавал олон улсын франчайз эрхтэй аудитын компани байх ёстой гэдэг шалгуур тавьсан. Тус шалгуурын хүрээнд сонгон шалгаруулалт явуулж 2021 онд “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК-ийг сонгосныг тайлбарлав.

“Мандал Даатгал” ХК-ны 2022 оны 08 сарын 04-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 22/010 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ны 2022 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Пи Кэй Эф Монголий Аудит” компанийг сонгосон.

Дүгнэлтийн товч агуулга: Бид “Мандал Даатгал” ХК-ийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 16-ны өдрийн ээлжит хурлын 22/001 тоот шийдвэрээр 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав.

Учир нь бид ногдол ашиг тараахгүй байснаар компанийн хөрөнгө оруулалтын багц нэмэгдэх, ингэснээр ирэх жилийн ашиг нэмэгдэх эерэг үр дагавартай болохыг тайлбарлав.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Мандал Даатгал ХК-ийн эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2022 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

ТУЗ нь дүгнэлтэй үндсэн хоёр хэсгээс бүрдүүлсэн хийсэн бөгөөд 1-р хэсэгт Санхүүгийн үр дүн
Үүнд: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ нь 2021 оны 12 сарын 01-ны өдрийн 21/015 тоот ТУЗ-ийн ээлжит хурлын тогтоолоор Мандал Даатгал ХК-ийн 2022 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан. Мандал Даатгал ХК 2022 онд нийт 69,7 тэрбум төгрөгийн хураамжийн орлогод хүрсэн нь Мандал Даатгал ХК-ийн хувьд түүхэн хамгийн өндөр орлого олсон жил болсон, татварын дараах цэвэр ашиг 4.1 тэрбум төгрөгт хүрсэн, салбартаа санхүүгийн үзүүлэлтээрээ тэргүүлэгч байсан. Компанийн мөнгөн хөрөнгө 39,9 тэрбум төгрөгт хүрч хөрөнгө оруулалтын 4.9 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн нийт хөрөнгө 73.6 тэрбум төгрөгт хүрсэн.

2022 онд Мандал Даатгал ХК нь даатгуулагчдаа нийт 11,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр өгсөн байна. “Пи Кэй Эф Монголий Аудит” ХХК-ийн дүгнэлтээр Мандал Даатгал ХК-ийн Санхүүгийн тайланг Олон Улсын Стандартын дагуу тайлагнагдсан гэсэн дүгнэлт гарсан.

ТУЗ нь дүгнэлтийн хоёр дах хэсэг нь Нийгмийн харилцааны хүрээнд хийсэн ажлыг дүгнэсэн
Үүнд: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзоригийн санаачилгаар 2022 онд нийт 50 хүний амь нас аврах ажлын хүрээнд 2 ажил хийгдсэн. Үүнд:

1. ТУЗ-ийн даргын санаачилгаар 50 хүний амь нас аврах төслийн хүрээнд Улсын 3-р Төв Эмнэлэгтэй хамтран Алтөпчлэг эмийг авч өгснөөр, зүрхний хурц шигдээс, тархины харвалт өгсөн 18 хүний амь насыг аварсан.
2. ОБЕГ-тай хамтран үеэр усны ослоыг бууруулах зорилгоор Туул голын эрэг дагуу хамгийн их хүн цуглардаг 2 байршилд аюулыг мэдээлэх 2 цамхгийг байгуулснаар тус байршилд 2022 онд үеэр усны ослоос үүдэлтэй эндэгдэл осол гараагүй байна.

2022 онд Мандал Даатгал ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан тул Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. гэснийг танилцуулав.

5 ДУГААР АСУУДАЛ:

ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Үүнд:

Компанийн ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн, хараат бус гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нийт 10 хүний 2023 оны жилийн цалин урамшуулал 154,0 сая төгрөг, Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын зардал 20,0 сая төгрөг, Бичиг хэрэг болон бусад зардал 6,0 сая төгрөг нийт 180,0 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

Асуулт, Хариулт

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултад хариулахыг тайлбарлав. Мөн хуралд ирсэн хувьцаа эзэмшигчд заалнаас асуулт асууж хариулав.

Асуулт 1:

Ногдол ашиг тараах уу?

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг:

Мандал Даатгал ХК нь 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн. Ингэснээр хөрөнгө оруулалтын багц нэмэгдэж мөн ирэх жилийн цэвэр ашиг нэмэгдэх давуу тал бий болно. Энэ жилийн татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг олгох эсэх шийдвэрийг бид одоогоор гаргаагүй байгаа бөгөөд хуулийн дагуу санхүүгийн жил дууссанаас хойг 20 хоногийн дотор буюу 2 сарын 19-ны дотор шийдвэр гаргадаг. ТУЗ 2024 оны 2 сарын 19-ны өдрөөс өмнө хуралдаж шийдвэр гаргана тэр даруйдаа хувьцаа эзэмшигчдээ танилцуулна.

Асуулт 2:

Мандал Даатгал ХК хувьцаагаа худалдан авч халааслах уу?

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг:

Одоогоор Гүйцэтгэх захирал болон ТУЗ -өөс хувьцаа халааслах шийдвэр болон тийм асуудал хэлэлцээгүй байгаа тул үгүй гэж хариулж байна.

Асуулт 3:

Мандал Даатгал ХК болон Тэнгэр Даатгал ХХК нэгдэх үү?

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг:

Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн удирдаж буюу хөрөнгө оруулалтын сан Тэнгэр Даатгал ХХК-ийн 100%-ийн энгийн хувьцааг худалдан авсан. Бидний зүгээс хоёр даатгалын компанийг нэгтгэх асуудал яригдаагүй тул таны асуултад одоогоор үгүй гэж хариулж байна.

Асуулт 4:

2023 оны өнөөдрийн байдлаарх борлуулалт өмнөх онтой харьцуулбал хэр байгаа вэ?

Даатгалын салбар ирэх жилүүдэд өсөлт үзүүлэх үү?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул:

Даатгалын тухай хуульд өөрчлөлт орж байгаа. Шинэчлэгдсэн хуулийн төсөлд заавал даатгуулах даатгал нэмэгдэх байх гэсэн хүлээлтэй байгаа. Тэгвэл Даатгалын зах зээл тэлэх бөгөөд тэр хэрээр даатгалын компаниудын орлого болон ашиг нэмэгдэнэ. Энэ жилийн эхний улирлын борлуулалтын орлого өмнөх жилийн 1-р улирлын борлуулалтын орлогоос давсан үр дүнтэй гарсан байгаа.

Асуулт 5:

Мандал Даатгал ХК нэмж хувьцаа гаргах уу?

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг:

Мандаг Даатгалын хувьд нэмэлт хөрөнгө оруулалт татах шаардлага одоогоор байхгүй байгаа тул нэмж хувьцаа гаргахгүй.

САНАЛ ХУРААЛТ

Асуулт хариулт дуусаж хурлын дэгийн дагуу санал хураалт эхэлснийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зарлав.

Санал хураалт авах аргачлалын танилцуулга: Цахимаар хэрхэн санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Г.Баасанбат

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Мандаг Даатгал” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,422,676 ширхэг хувьцааны санал буюу 99,99 хувийн саналаар 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

ТУЗ-ийн 2023 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,466,541 ширхэг хувьцааны санал буюу 99,99 хувийн саналаар ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.


Санал хураалт дууссаныг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зарлав.

Тооллогын комиссын дарга Г.Баасанбат: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандаг Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга хурлын хаалтыг үгийг хэлснээр 17 цаг 35 минутад хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨСӨН



Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦУУЛ

Ө.ГАНЗОРИ

Хурлын дарга